



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 06

Чойр

Төрийн болон орон нутгийн
өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг
тооллогын дүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4, 77 дугаар зүйлийн 77.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтууд, Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай" 09 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн "Маягт батлах тухай" 323 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор Орон нутгийн өмчит 43 хуулийн этгээдийн нийт 87,865,215,550.84 (наян долоон тэрбум найман зуун жаран таван сая хоёр зуун арван таван мянга таван зуун тавин төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн үндсэн хөрөнгийг дор дурдсанаар баталсугай.

1.1. Барилга, байгууламж 44,539,453,470.79 (дөчин дөрвөн тэрбум таван зуун гучин есөн сая дөрвөн зуун тавин гурван мянга дөрвөн зуун далан төгрөг далан есөн мянга) төгрөг;

1.2. Газар 7,361,959,800 (долоон тэрбум гурван зуун жаран нэгэн сая есөн зуун тавин есөн мянга найман зуу) төгрөг;

1.3. Нийтийн эзэмшил 8,548,122,892.75 (найман тэрбум таван зуун дөчин найман сая нэг зуун хорин хоёр мянга найман зуун ерэн хоёр мянган төгрөг далан таван мөнгө) төгрөг;

1.4. Машин тоног төхөөрөмж 12,544,637,248.06 (арван хоёр тэрбум таван зуун дөчин дөрвөн сая зургаан зуун гучин долоон мянга хоёр зуун дөчин найман төгрөг зургаан мөнгө) төгрөг;

1.5. Авто тээврийн хэрэгсэл 3,195,215,703.79 (гурван тэрбум нэг зуун ерэн таван сая хоёр зуун арван таван мянга долоон зуун гурван төгрөг далан есөн мөнгө) төгрөг;

1.6. Тавилга эд хогшил 3,355,209,486.05 (гурван тэрбум гурван зуун тавин таван сая хоёр зуун есөн мянга дөрвөн зуун наян зургаан төгрөг таван мөнгө) төгрөг;

1.7. Худаг услалтын систем 981,971,802 (есөн зуун наян нэгэн сая есөн зуун далан нэгэн мянга найман зуун хоёр) төгрөг;

1.8. Авто зам 6,989,377,749 (зургаан тэрбум есөн зуун наян есөн сая гурван зуун далан долоон мянга долоон зуун дөчин ес) төгрөг;

1.9. Гүүр 0 төгрөг;

1.10. Биет бус хөрөнгө 264,799,673.40 (хоёр зуун жаран дөрвөн сая долоон зуун ерэн есөн мянга зургаан зуун далан гурван мянга дөчин мөнгө) төгрөг;

1.11. Түүх, соёлын дурсгалт зүйл 84,467,725 (наян дөрвөн сая дөрвөн зуун жаран долоон мянга долоон зуун хорин тав) төгрөг;

2. Аймгийн Засаг даргад дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1. Тооллогын үр дүнгээр гарч ирсэн илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг судлан холбогдох шийдвэрийг гаргуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийн доод эзэмшлийн газрыг өөрийн байгууллагын нэр дээр аваагүй барилга байгууламжийн газрыг 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж олгох;

2.3. Тээврийн хэрэгслийн зөрчлийг мэргэжлийн байгууллагатай хамтарч 2022 онд багтаан арилгах;

3. Тооллогын дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт заасан хугацаанд хүргүүлж, нэгтгүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Болд-Эрдэнэ)-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Ж.Оюунбилэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.БИЛЭГГҮМБЭРЭЛ